



GOETHE DELIVERY OWL

Goethe International School Monthly Newspaper



Сайн байцгаана уу? Эрхэм уншигч таны энэ өдрийн амар амгаланг айлтгая!

Гёте олон улсын сургуулийн "Goethe Delivery Owl" сонины редакцаас мэндчилж байна. Бид та бүхнийг сар бүр мэдээ мэдээллээр тогтмол хангах болсныг дуулгахад туйлын таатай байна. Манай редакц багш, сурагчдаас бүрдсэн нийт 13 гишүүнтэй үйл ажиллагаагаа эхлүүлж байна.

FIRST PUBLICATION

- OWL INTERVIEW
- VISION/QUOTE
- JUST FOR YOU
- CHANNEL TEA/RECOMMENDATION
- ACCOMPLISHMENT OF THE YEAR
- WHAT'S COMING NEXT MONTH?



@GOETHE_SCHOOL_NEWSPAPER

Манай хамгийн анхны нийтлэлийг сонирхон уншиж буй танд талархъя. Уншиж дуусаад, санал хүсэлтээ бидний инстаграм хаягаар илгээгээрэй.

www.goetheschule.edu.mn



Амира

OWL INTERVIEW

Бид "Owl Interview" булангаараа сурагчдын мэдэхийг хүсэж буй асуултуудад хариулт өгөх зорилгоор сургуулийн багш, сурагчид, ажилтнуудаас ярилцлага авах юм. Эхний дугаарт үйл ажиллагаа хариуцсан захирал Б.Дэлгэрнарантай 9b ангийн сурагч Е.Амира болон 11a ангийн сурагч Э.Дөлгөөн нар ярилцлаа.

Өдрийн мэнд, та сайн байна уу? Өнгөрсөн сард сурагчдаас сар болгон түвшин тогтоох шалгалт авч, хангалттай дүн авч чадаагүй сурагчдын "Сургалтын гэрээ"-г сунгахгүй гэдгийг анги удирдсан багш нар мэдээлсэн. Энэ шалгалтыг тогтмол авах эсэх болон яагаад авч байгаа талаар мэдээлэл өгнө үү?

Дэлгэрнарэн



Манай сургууль 20 жил үйл ажиллагаа явуулж байна. Төгсөгчдийн 70% нь гадаадын их, дээд сургуулиудад элсэн орж суралцдаг билээ. Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдүүдээ герман хэл болон "Кембрижийн хөтөлбөр"-т амжилттай сайн суралцуулахын тулд манай сургуульд оруулдаг билээ. Ийм учраас бид хүүхдүүдийн ахицыг байнга хянах шаардлагатай. Магадгүй энэ явцын шалгалт нь хүүхэд бүрийг хичээл зүтгэлээ алдахгүй мэрийхэд гол түлхэц болно гэж би итгэж байна.

Амира

Ахлах ангийн хүүхдүүд өглөө 8 цагт ирээд орой 17 цагт харих нь элбэг ба өдөрт дунджаар 9 цагийг сургууль дотор өнгөрүүлж байна. Цаашид хичээлийн цаг энэ хэвээр байх уу? Ийм их цагаар хичээл хийх нь хэр зөв гэж таны хувьд бодож байна вэ?

Олон шалгалт өгөхийн хэрээр бэлдэх хугацаа их шаарддаг тул хичээлийн цагийг хангалттай гаргах нь зүйтэй. Мөн хүүхдүүдийн эцэг эхчүүд нь сурагчдыг өглөө эрт ажилдаа очихынхоо өмнө хүргэж өгөх хэрэгтэй болдог. Монгол улс ажил, хичээлийн цагаа урагшлуулах хэмжээнд хүрээгүй байгаа тул гадаадын орнуудын адил цагаа урагшлуулах болоогүй байна. Нэмж дурдахад ихэнх сурагчид маань Германд суралцах зорилготой тул тэндхийн боловсролын систем нь хүүхдийн биеэ даах байдал болон чадавхийг илүү сорьдог болохоор Гёте сургууль гадаадын боловсролтой тэнцэхүйц хүүхдүүдийг бэлтгэдэг. Хэдийгээр цаашид хичээллэх цаг өөрчлөгдөхгүй ч гэсэн миний хувьд хэрвээ сурагч өөрийгөө идэвх сул болон ядаргаанд орсон гэж үзвэл амрах хэлбэрүүдээ өөрчлөх эсвэл шинэ зүйлсийг туршаарай хэмээн зөвлөө.



Амира

Хамгийн сүүлийн асуултаа асууя. Таны хувьд сурагчдыг ямар дадал зуршилтай болбол өөрт нь хэрэгтэй гэж бодож байна вэ?

Миний хувьд сурагчдыг дараах дадал зуршлыг эзэмшээсэй хэмээн хүсэж байна. Тухайлбал:



- Creativity -бүтээлчээр сэтгэх чадвар. Хүн ямар ч ажил хийсэн бай, шинэлэг бүтээлчээр хийх ёстой гэж үзэж байна.
- Humanity -нийгмийн харилцаанд орохдоо ярилцаж, байгаа хүнийхээ нөхцөл байдлыг ойлгож харилцах.
- Sustainability - Өөрийн сэтгэлийн болон биеийн эрүүл мэндийн тэнцвэрийг хадгалан амьдарч суралцах.



Түүнчлэн мэдээж хэрэг тогтмол ном унших нь зүй ёсоор багтана. Ном уншдаг хүмүүсийн ухаан ерөнхий математик гэх мэт хичээлүүдэд хэрэглэгдэхгүй ч эсээ бичүүлэх үед дотоод сэтгэлгээгээр нь илэрдэг. Ирэх хичээлийн жилээс “Жилд 20 ном унших” аяныг 9-12-р ангийнхны дунд зохион байгуулахыг зорьж байна. Хамгийн том үр дүнг авчирдаг зүйл гэвэл өөрийн сонирхож буй зүйлдээ тууштай байх гэж бодож байна.

Амира

Goethe Delivery Owl сонины анхны дугаарт ярилцлага өгсөн Б.Дэлгэрнаран захиралдаа маш их баярлалаа. Уншигч та дараагийн ээлжинд хэнтэй ярилцахыг хүсэж байна вэ?

Quote

"Би бусадтай санал нийлэхгүй байсан ч гэсэн бусдын санаа бодлыг хүндэтгэх ёстой."

Герберт Х.Леман

"Хүндэтгэл нь өгөх, хүлээн авах гэсэн хоёр өөрчлөгдөшгүй үе шаттайгаар ирдэг."

Эдмон Мбиака

Бэлтгэсэн: 10а ангийн сурагч Б.Ундрал

Just For You

Нойр бол амьдралын түлхүүр

21дүгээр зууны хүүхдүүдийн сэтгэл санааны байдал 1954 оны сэтгэцийн эмнэлэгт байсан хүмүүсийнхтэй ижил төстэй байна гэж эрдэмтэд судалжээ. Хүн өдөрт дөрвөөс таван цаг унтвал сэтгэл гутралд өртөх магадлал 2 дахин ихэсдэг байна. Тэгвэл энэ удаагийн "Just For You" булангаар үр дүнтэй унтах хоёр аргыг зааж өгье.

■ арга бол халуун болон хүйтэн усанд орох.

Халуун усанд орох нь стрессээс ангижруулж, булчин шөрмөсийг тайвшруулдаг. Харин хүйтэн усанд орох нь арьсыг толигор болгон, энерги нөхөж, өглөө сэргэг сэрэхэд тусалдаг. Ингэхдээ долоо хоногт 2-3 удаа өглөө цайгаа уухынхаа өмнө хүйтэн усанд, орой унтахынхаа өмнө халуун усанд орвол нэн тохиромжтой.

■ арга бол бодлоо цаасан дээр буулгах.

Хүн ихэвчлэн орондоо маргаашдаа санаа зовох, эсвэл дурсамжуудаа бодож унтаж чаддаггүй. Харин бодлоо цаасан дээр буулгах үед бид толгой дотроо бодох зүйлгүй болж илүү хурдан унтах болно.



Зурсан : 11а ангийн сурагч Х.Хантуул

Нийтлэлд ашигласан эх сурвалжууд:


Саак судалгаа: **Холбоос Халуун болон хүйтэн ус бидний биед хэрхэн нөлөөлдөг вэ?**

Эрхэлсэн: 11а ангийн сурагч Т.Төгөлдөр



We Are Recommending

Movie recommendation-Me Before You



Me before you киног анх Jojo Moyes-ийн зохиолоос санаа авч бүтээсэн бөгөөд 2016 оны 6 сарын 3нд нээлтээ хийжээ. Киноны ерөнхий найруулагчаар Thea Sharrok ажилласан бөгөөд Emilia Clarke, Sam Claflin, Janet McTeer нар гол дүрийг бүтээжээ.

Киноны эхэн хэсэгт Louissa Clark хэмээх залуу бүсгүйн ажилладаг байсан кафе нь санхүүгийн хямралын улмаас хаалгаа барьснаас үүдэн, шинэ ажил хайх хэрэгтэй болдог. Ярилцлага өгч байх үеэрээ бяцхан алдаа гаргасан ч түүний цайлган, баясгалантай занд татагдсан гэрийн эзэгтэй түүнийг ажилд авдаг. Ярилцлагандаа тэнцсэн тэрээр осолд орж, хүзүүнээсээ доош мэдрэлээ алдсан Will Траунор-ийг асрахаар болдог. Асрах явцад тэрээр амаргүй бэрхшээлүүдтэй тулгарах бөгөөд эцэст нь Will-тэй дотноссоноор бие биеийнхээ амьдралд хэсэгхэн хугацаанд ч гэрэл гэгээ цацруулдаг.

Кино шүүмжлэгчдээс тийм ч өндөр үнэлгээ аваагүй кино ч үзээд харамсахгүй гэдэгт итгэж байна. Мөн үзээд жаахан ч гэсэн юм тунгаан бодох байх гэдэгт найдаж байна. Киноны насны хязгаар нь +14 бөгөөд энэхүү кино нь **1 цаг 50 минутын** хугацаатай ба та Apple TV, YouTube, Google Play Movies-ээс хүлээн авч үзэх боломжтой.

Бэлтгэсэн: 10а ангийн сурагч Б.Ундрал



Зурсан : 11а ангийн Х.Хантуул

Accomplishment Of The Year

2022-2023 оны хичээлийн жилийн хувьд манай сургууль олон төрлийн амжилтаар дүүрэн байна. Сурагчдын амжилтуудыг нэгтгэн уншигч та бүхэндээ хүргэе.

Дүүрэг, нийслэлийн хэмжээнд гаргасан амжилтууд

- 1.БЗД-ийн Нийгэм судлалын хичээлээр 9а ангийн сурагч **Б.Цолмон** Дүүргээс алт, Нийслэлээс мөнгөн медалийн эзэн болжээ.
- 2.БЗД-ийн Математикийн олимпиадад 7б ангийн сурагч **Б.Намуундарь** 2-р байр эзлэв.
- 3.БЗД-ийн Монгол хэлний олимпиадад 6б ангийн сурагч **Ч.Намуун** 2-р байранд оров.
- 4.БЗД-ийн Түргэн Бичилт компьютерын уралдаанд 12б ангийн сурагч **Л.Төгссанаа** 3-р байранд орлоо.
- 5.БЗД-ийн Техник Технологийн XXIV олимпиадын “Усан загвар”-ийн хийцийн төрөлд 9а ангийн сурагч **С.Чинсэтгэл** II байр эзэлсэн.
- 6.БЗД-ийн Англи хэлний олимпиадад 9,12 ангийнхан оролцож,
12-р ангиас: 1-р байр 12А **Г.Лундаажанцан**, Нийслэлд 2-р байр
Тусгай байр 12А **О.Амингоо**
Тусгай байр 12Б **Б.Амарбаясгалан**
9-р ангиас: Тусгай байр 9Б **Б.Булган** нар тус тус байр эзэллээ.

Олон улсын Кембрижийн шалгалтад гаргасан амжилтууд

AS & A Level математикийн шалгалтад:

- 12а ангийн сурагч **Д.Саруул**
 - 12а ангийн сурагч **Б.Намуундарь**
- IGCSE Level-ийн англи хэлний шалгалтад:
- 11а ангийн сурагч **Э.Цэнд** тус тус өгөн тэнцжээ.

Сургуулийн амин сүнс болсон герман хэл дээр гаргасан амжилтууд

- 1.10а ангийн сурагч **Е.Мандалмаа** нь ХБНГУ-ын элчин сайдын яаманд зохиогддог PAD-ийн тэмцээнд 1-р байрыг эзэлсэн.
- 2.Мөн сурагчдын минь гол зорилго, мөрөөдөл болсон диплом №2-ын шалгалтад **13 хүүхэд** амжилттай өгсөн байна.

Спортын амжилтууд

- 1.Манай сургуулиас дахин нэг спортын 2-р зэрэгтэй тамирчин төрсөн нь 9а ангийн сурагч **Б.Цэнгүүн** нь UNC-2023 УАШТ-д туялзуур сэлмээр ганцаарчилсан төрөлд хүрэл, багийн төрлөөр алтан медалийг хүртэв.
- 2.МШКК Холбооны 9 дахь удаагийн “FULL CONTACT KARATE CHAMPIONSHIPS 2023” тэмцээнд 9б ангийн сурагч **Ө.Баасандорж** тулааны төрөлд алтан медалийн эзэн болжээ.

Сургуулийн Аварга Шалгаруулах Тэмцээн

Жил бүр сургуулиас зохиогддог гар бөмбөг, сагсан бөмбөгийн “Сургуулийн аварга” шалгаруулах тэмцээн 4 сарын 11-14 хооронд болсон билээ.

- Гар бөмбөгийн тэмцээний ялагчид: Эрэгтэй төрөлд **106 анги**, эмэгтэй төрөлд **96 анги**
- Сагсан бөмбөгийн тэмцээний ялагчид: Эрэгтэй төрөлд **126 анги**, эмэгтэй төрөлд **12а анги**

тус тус оролцож хурд хүч, авхаалж самбаагаа уралдуулсан тамирчид, сурагчдадаа баяр хүргэе. Цааш цаашдын хичээл сурлага номд нь амжилт хүсье.

Эмхэтгэсэн: 11б ангийн сурагч Б.Солонго
11б ангийн сурагч Б.Ганболор

What Is Coming Up Next

Сургуульд болох эвент

1.5 сарын 2: Герман хэлний А1 бичиг, яриа, сонсгол, унших шалгалт

2.5 сарын 4: Герман хэлний А2 бичгийн шалгалт

3.5 сарын 8-9: Герман хэлний А2 ярианы шалгалт

4.5 сарын 12: Хонхны баяр

5.5 сарын 15-26:

- 8-р ангийн сурагчдад мэргэжил сонголт болон Cambridge IGCSE түвшний хөтөлбөр
- 10-р ангид Cambridge AS/A түвшний хөтөлбөр
- 9-11-р ангиудад ирэх жилийн урьдчилсан хичээл (Cambridge) сонголт тус тус танилцуулна.

Сургуулиас гадуурх эвент

1.5 сарын 6: ЕБС-ийн 10-11 ангийн сурагчдад зориулан сургуулиа төгссөн жилдээ гар year авахгүйн тулд гадаадад суралцах төлөвлөгөө гаргах талаар 2 өдрийн танхимын сургалт. Дэлгэрэнгүй мэдээллийг “[Youth opportunities Mongolia](#)” facebook хуудаснаас авна уу.

2.5 сарын 13: “TomYo Talk 2023” илтгэл болон энтертайнмент хосолсон эвент. Дэлгэрэнгүй мэдээллийг bit.ly/TomYo-Talk нэвтрэн уншина уу.

Бэлтгэсэн : 11а ангийн сурагч С.Бямбатүвшин

Designed by : 11б ангийн сурагч Б.Сувдбилиг